



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2016 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 50

Алтай

Нэрэмжит болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12, Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор батлагдсан "Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг мөнхжүүлэх журам"-ын 6 дугаар хэсгийн 6.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Алтай сумын Хилийн 0214 дүгээр ангийн Соёл мэдээллийн төвийг алдарт дуучин Пэлжээгийн Адарсүрэнгийн нэрэмжит болгосугай.

2. Алдарт дуучин Пэлжээгийн Адарсүрэнгийн нэрэмжит Соёл мэдээллийн төвийн хаяг, албан хуудасны загвар баталж, нэрэмжит болгосонтой холбоотой ажил үйлсийг хойч үеийнхэнд таниулж, гавьяат үйлсийг нь алдаршуулан ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/, Ангийн захирагч, дэд хурандаа /Б.Гантөмөр/ нарт даалгасугай.



ДАРГА  Т.ГАНЗОРИГ